



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2020 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 36

Мандалговь

Үндсэн хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт шаардлагатай нийт 51,268,100 /тавин нэгэн сая хоёр зуун жаран найман мянга нэг зуун/ төгрөгийн тоног төхөөрөмжийг хавсралтын дагуу бэлтгэж үндсэн хөрөнгөнд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

Хоёр. Аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын дарга (Б.Мөнхжаргал)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай. Үүнд:

2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2020 оны 4 дүгээр сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх;

Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ) -д үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 23 дугаар сарын
23-ний өдрийн 28 тогтоолын хавсралт



Хүнс хөдөө аж ахуйн газрын үндсэн хөрөнгөнд бүртгэх жагсаалт

№	Нэр	Нэг бүрийн үнэ	Хэмжих нэгж	Тоо	Дүн
1	Фургон УАЗ-22069	36,000,000.00	ш	1	36,000,000.00
2	Усны түвшин хэмжигч 150 метр	3,779,600.00	ш	1	3,779,600.00
3	Санхүүгийн программ	1,500,000.00	ш	1	1,500,000.00
4	Чанга яригч	320,000.00	ш	1	320,000.00
5	Гар GPS 64	815,000.00	ш	1	815,000.00
6	Дарга сандал	1,269,900.00	ш	1	1,269,900.00
7	Dell-lt ins 3593 notebook	1,899,900.00	ш	1	1,899,900.00
8	Dell-lt ins 558 note book	2,799,900.00	ш	1	2,799,900.00
9	Принтер M130A	419,900.00	ш	1	419,900.00
10	Тоос сорогч / Dapa-Mc YL635 /	549,900.00	ш	1	549,900.00
11	Epson l1300 өнгөт принтер	1,320,000.00	ш	1	1,320,000.00
12	Свийч /1016 /	594,000.00	ш	1	594,000.00
Нийт дүн				12	51,268,100.00 /тавин нэгэн сая хоёр зуун жаран найман мянга нэг зуун төгрөг/